


Excel 2007-ын үндсэн ойлголт ↑

Excel программ дээр хүснэгтэн мэдээлэл боловсруулвал оновчтой. Excel программ дээр үүсгэсэн файл нь *.xls (Excel 2007-оос өмнөх хувилбаруудад), *.xlsx (Excel 2007) өргөтгөлтэй болж хадгалагддаг.

Excel 2007-г эхлүүлэх:

1. Start->Programms->Microsoft 2007-> Excel 2007
2. Start->Run->Excel гэж бичээд enter дарна.
3. Excel дээр үүсгэсэн файлыг нээх замаар эхлүүлж болно.

Excel 2007-ын цонхны бүтэц ↑



MS-Office-ийн буюу Excel-ийн товч нь цонхны зүүн дээд буланд байрлана. Энэ товчин дээр дарахад шинэ файл байгуулах, бэлэн байгаа файлыг нээх, файлыг хадгалах болон өөр бусад олон үйлдлийг хийх боломж олгодог цэс нээгдэнэ.

Хурдан хандалтын хэрэгслийн самбар. MS-Office-ийн товчны баруун талд Quick Access toolbar /Хурдан хандалтын хэрэгслийн самбар/ байрлана. Энэ хэрэгслийн самбар нь таны байнга хэрэглэдэг командууд руу хурдан хандах боломжийг олгоно. Стандарт тохиргоогоор хурдан хандалтын хэрэгслийн самбар дээр save, undo, Redo командын товчнууд харагдаж байдаг. Үүн дээр команд нэмэхийг хүсвэл Excel-ийн товчин дээр дарж Excel options руу орж нээгдэх харилцах цонхноос Customize хэсгийг сонгоод тэндээс өөрт хэрэгтэй командаа сонгон Add товчин дээр дараад ОК дарна.

Гарчгийн мөр. Гарчгийн мөрөн дээр ажлын хавтасны нэрийг харуулна. Хэрвээ та ажлын хавтасандаа нэр өгч хадгалаагүй байгаа бол файлын нэрийн оронд Excel-ийг ачаалсанаас

хойш хэд дэх ажлын хавтсыг нээгээд байгааг харуулсан Book1-Microsoft Excel гэсэн нэрийг харуулна.

Командын хэрэгслийн самбар. Командын хэрэгслийн самбарын дээд талд хэд хэдэн таб байдаг. Табан дээр дарахад хоорондоо логик уялдаа холбоотой командуудын бүлгүүд гарна. Бүлэг болгон хоорондоо логик логик уялдаа холбоотой командуудыг агуулна. Жнь: Insert таб нь янз бүрийн хүснэгт зураг, график диаграмм, текст, холбоос оруулах зэрэг үйлдлийг хийдэг командуудыг агуулсан бүлгүүдээс тогтоно. Командыг ажиллуулах эсвэл цэс болон харилцах цонх руу хандахын тулд та тэдгээр товчнууд дээр дарна. Бүлгийн баруун доод буланд харилцах цонхыг нээгч товч байж болно. Харилцах цонхны нээгч дээр дарахад нэмэлт командуудыг агуулсан харилцах цонх нээгдэнэ. Та командын хэрэгслийн самбарын табуудын мөрөн дээр хулганы баруун товчыг дарж гарч ирсэн хураангуй цэснээс Minimize the Ribbon/Командын хэрэгслийн мөрийг жижигрүүлэх/ командыг сонгон энэ самбарыг нууж, ажлын хуудасны харагдах талбайг нэмэгдүүлж болно. Энэ үйлдлийг давтан командыг хэрэгслийн самбарыг буцааж ил харуулж болно.

Томъёоны мөр. Excel-ийн цонхон дотор ажлын хуудасны яг дээд талд томъёоны мөр /Formula bar/ байрлана. Хэрэв томъёоны мөр идэвхтэй байвал түүний зүүн талд идэвхтэй нүдний хаяг харин баруун талд идэвхтэй нүдний өгөгдөл буюу агуулга харагдана. Хэрвээ томъёоны мөр цонхонд харагдахгүй бол ил гаргахдаа View таб руу орж Show/Hide бүлэг доторх Formula bar дээр дарна. Нуухдаа мөн энэ командыг сонгоно.

Төлөв байдлын мөр. Excel-ийн цонхны хамгийн доод талд байрлаж сонгож ялгасан тоонуудын нйлбэр, дундаж, минимум, максимум зэрэг мэдээллээр хангана. Та төлөв байдлын мөрөн дээр хулганы баруун товчийг дарж Customize Status bar цэснээс хүссэн командыг сонгож төлөв байдлын мөрөн дээр харуулах мэдээллийг өөрчилж болно. Та цэсний командыг сонгохын тулд түүн дээр нэг дараарай. Харин командыг идэвхгүй болгохын тулд түүн дээр дахин дараарай.